

СЭРГЭЭН ЗАСАХ АМРАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2020.07.10

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын баталсан 2020 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн “ИНЕГ-ын Сэргээн засах амралтын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай” 17/20 тоот удирдамжийн хүрээнд 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 07 дугаар сарын 10-ны өдрийг дуустал хугацаанд ИНЕГ-ын Сэргээн засах амралтын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны ахлах аудитор Л.Жаргалсайхан, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Ц.Цацрал, Б.Болормаа нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг дотоод аудитыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Сэргээн засах амралтын 2019 оны 05 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааны касс, харилцах дансны үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, анхан шатны баримт бүрдүүлэлт, захиргаа, дотоод хяналтын үйл ажиллагаа, мөрдөгдөж буй дүрэм, журмын хэрэгжилт, шилэн дансны хуулийн хэрэгжилт, бараа материалын бүртгэл зэргийг нягталж шалгахгаас гадна зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа. Зарим үйл ажиллагааны хамрах хүрээг аудитын нөхцөл байдлаас шалтгаалан 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс тооцсон болно.

Сэргээн засах амралтын даргын тушаалын төсөл боловсруулахдаа хууль эрх зүйн үндэслэлээ нягтлаагүй, хөдөлмөрийн дотоод журмын зүйл заалтыг оруулаагүй байна.

2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд ирсэн хариутай албан бичгүүдийн шийдвэрлэлтийн талаар бүртгэл-хяналтын картанд тэмдэглэл хийгээгүй байна.

Бараа материалыг нягтлан бодох бүртгэлд бүртгэлд тусгахдаа шаардлагагүй олон бүлгээр ангилах, дансыг зөв сонгоогүйгээс бараа материалын нийт үлдэгдэл зөв боловч бүлгийн үлдэгдлүүд буруу илэрхийлэгдсэн.

Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгүүдийг бүртгэсэн байна.

Захиргааны мэргэжилтэн цалинтай чөлөө авсан ажилтнуудын цагийн бүртгэлийг гаргахдаа чөлөөний утгыг тодорхой болгож өгөөгүйгээс хоолны үнийн хөнгөлөлт илүү олгогдсон.

Veritech ERP цогц системийн “Санхүүгийн цогц иж бүрэн програм”-ын ашиглалт хангалтгүй байна.

Гэрээний хугацаа дуусгавар болсон ч гэрээг үргэлжлүүлж байгаа, гэрээг хэн төлөөлж байгуулсан нь тодорхойгүй, гэрээний заалтад байхгүй дугаарыг гэрээний бичвэрт оруулсан зэрэг зөрчлүүд илэрсэн. Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаа хоцроох, буруу, дутуу мэдээлж байсан дутагдлаа залруулан ажиллаж байна.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар Иргэний нисэхийн үндэсний төвд 2, тус нэгжид 12, нийт 14 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА